



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 13 өдөр

Дугаар A/461

Хэрлэн сум

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх  
дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9 дэх заалт, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2022 оны А/191 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх намрын дархлаажуулалтын арга хэмжээг аймгийн хэмжээнд бүх үхэр, гахайг хамруулан 2022 оны 9 дүгээр сарын 15-аас 20 хоногт багтаан шуурхай зохион байгуулсугай.

2. Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн хүрээнд технологит хугацаанд нь гүйцэтгэх, уг ажлын чанар, явц, гүйцэтгэлд хөндлөнгийн хяналт тавьж ажиллах аймгийн Онцгой комиссын гишүүдийн хуваарийг хавсралтаар баталсугай.


3. Малчдад урьдчилан мэдэгдэж тарилгын хашаа, хоолойг бэлтгүүлэх, урьдчилан сэргийлэх тарилгад ажиллах хүн хүч, машин техник, шатах тослох материалын бэлэн байдлыг хангаж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

4. Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлсхийсэн малчид, мал бүхий иргэд, заавар, журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нөхцөлийг бүрдүүлсэн албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар, Мал эмнэлгийн газрын улсын байцаагч нарт үүрэг болгосугай.

5. Дархлаажуулалтад шаардлагатай вакцин, мэргэжил арга зүйн заавар зөвлөмжөөр хангах, гүйцэтгэлийг хянаж шалгах, үр дүнг танилцуулахыг Мал эмнэлгийн газар (Н.Анхбаяр)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ



**МАЛ, АМЬТНЫ ГОЦ ХАЛДВАРТ ШУЛХИЙ ӨВЧНИЙ ДАРХЛАДЖУУЛЛЫН АЖИЛДАЛЫН  
ХЯНАЛТ ТАВЬЖ, ХАРИУЦАН АЖИЛЛАХ ОНЦГОЙ КОМИССЫН ГИШҮҮДИЙН ХУВААРВ**



Д/д	Сумын нэр	Хяналт тавьж ажиллах Онцгой комиссын гишигчийн овог нэр	Албан тушаал	Засаг дарга
1	Галшар	Б.Дархантөр	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга	Д.Нямбаатар Утас: 99567878
2	Баянхутаг	Ж.Гантулга	Төрийн захирагааны удирдлагын хэлтсийн дарга	Б.Амгаланбат Утас: 98636699
3	Баянмөнх	Н.Алтанзэрэл	Тагнуулын хэлтсийн дарга	Б.Золжаргал Утас: 99278000
4	Дархан	Б.Сүнгээ	Мэргэжлийн хяналтын газрын дарга	Ж.Энхтөр Утас: 98091117
5	Дэлгэрхэсан	Ж.Ганбаатар	Засаг даргын Тамгын газрын дарга	Э.Төгөлдер Утас: 98632196
6	Жаргалтхаан	Ж.Эрдэнэбат	Онцгой байдлын газрын дарга	Л.Цэнгэл Утас: 92113175
7	Цэнхэрмандал	Э.Мөнх-Эрдэнэ	Хөгжлийн бодлого, төвлөрөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга	С.Золжаргал Утас: 97186060
8	Өмнөдэлтээр	Б.Дарханбаатар	Хууль зүйн хэлтсийн дарга	Б.Эрдэнэбаатар Утас: 88092147
9	Батширеэл	Н.Хүрэлээ	Цэргийн штабын дарга	Г.Гансүх Утас: 86067052
10	Биндэр	Л.Мэндбаяр	Эрүүл мэндийн газрын дарга	Мөнх-Очир Утас: 97031765
11	Баян-Адарга	Н.Анхбаяр	Мал эмнэлгийн газрын дарга	О.Лхагвадорж Утас: 98819081
12	Дадал	Д.Өнөрцэцэг	Нийгмийн бодлогын хэлтсийн дарга	Д.Мөнх-Од Утас: 93014267
13	Норовлин	Ч.Ганготгох	Онцгой байдлын газрын хошууч	А.Мөнхбаягаль Утас: 99665599
14	Батноров	Л.Өлзийбат	Улаан загалмайн хорооны дарга	Б.Жавхланбаяр Утас: 91114371
15	Баян-Овоо	Х.Үртнасан	Гэр бүл, хүүхэд запуучуудын хөгжлийн газрын дарга	Д.Баянмөнх Утас: 93191029

16	Мөрөн	С.Нямдаваа	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга	Ц.Батцоож Утас: 98022002
17	Хэрлэн	М.Шүрэнцэцэг	Хэрлэн сумын Засаг дарга	М.Шүрэнцэцэг Утас: 92113141
18	Бор-Өндөр	Д.Батхүү	Цагдаагийн газрын дарга	П.Чинбат Утас: 9993847